



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын
хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн алба
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай" хуулийн 13, 14, 19 дүгээр зүйлийн 19.1, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолын 169 дүгээр заалтын 3 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн албыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтцэд 2014 оны 11 дүгээр сарын 01-нээс эхлэн байгуулсугай.
2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн албаны үйл ажиллагааны чиг үүргийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтэц, орон тоог хоёрдугаар, чанарын хяналт, засвар үйлчилгээ тохиргоонд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гуравдугаар, эрүүл мэндийн байгууллагуудын зайлшгүй чанарын хяналт хийх шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг дөрөвдүгээр, ЭМЯ-ны харьяа байгууллага, лавлагаа төвүүдээс шилжүүлэн авах мэргэжилтнүүдийн тоог тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дээрх албаны орон тоог ЭМЯ-ны харьяа байгууллага, лавлагаа төвүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн мэргэжилтэнүүд болон бусад орон тооноос цалингийн сантай нь шилжүүлэх, бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-т тус тус даалгасугай.
4. Дээрх албаны үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах, 2014 оны төсөвт зохицуулалт хийхийг Санхүү эдийн засгийн хэлтэс /Д.Төмөрбаатар/, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Ч.Бат-Эрдэнэ/ болон холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга захирал нарт тус тус даалгасугай.
5. Шинээр алба байгуулсантай холбогдуулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

САЙД

Н.УДВАЛ

D:\barimt\tushaal

082162

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ,
СУРГАЛТ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн алба" нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарт оношилгоо, эмчилгээнд ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийн хэмжил зүйн хангалт /бүртгэл, судалгаа, шалгалт тохируулга, засвар-үйлчилгээ, сургалт/, холбогдох бодлого, хөтөлбөр, стандартыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа бүхий дараах хэсэг нэгжтэй ажиллана.

Хоёр. Албаны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

2.1 "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн алба" нь үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

2.1.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын оношилгоо, эмчилгээнд ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжид чанарын хяналт хийнэ.

2.1.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тохируулга, засвар үйлчилгээ

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналтын дараах шалгалт тохируулга, засвар үйлчилгээг гүйцэтгэнэ.

2.1.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл мэдээлэл, судалгаа

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл, нэршил ангилалыг олон улсын стандартын дагуу бий болгож, нэгдсэн мэдээний санг үүсгэн, мэдээллийн баяжуулалт, дэвшилтэт техник технологи, судалгаа хийнэ.

2.1.4 Эрүүл мэндийн салбарын инженер, техникч, эмч мэргэжилтнүүдийн сургалт

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд ажиллаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтан болон эмч, мэргэжилтнүүдэд мэргэжлийн болон ашиглалтын сургалтыг зохион байгуулна.

Гурав. Албаны эрх, үүрэг

3.1 ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ТОХИРГОО

3.1.1 Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагаа, стандарт, чанарын хяналтын асуудлыг хариуцан ажиллана.

3.1.2 Чанарын хяналтын системийг бүрдүүлэх, мөрдөх бодлогын бичиг баримт боловсруулж, ЭМЯ-аар батлуулан салбарын хэмжээнд мөрдүүлэх.

3.1.3 Тоног төхөөрөмж тус бүр дээр чанарын хяналт, үнэлгээ хийх аргачлал, хяналт тохиргоо хийх хуваарь, үнэ тариф болон бусад холбогдох журмыг боловсруулан батлуулах.

- 3.1.4 Хавсралт 4 -т заасан оношилгоо, эмчилгээнд хэрэглэж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хяналтын хэмжилт хийх, зөрчилтэй тоног төхөөрөмжийн ашиглалтыг хориглох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.
- 3.1.5 Шинээр нийлүүлэгдэж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагааг шалгах хэмжилтүүдийг хийх, хэмжил зүйн шаардлага хангаагүй тоног төхөөрөмжийг нийлүүлэгч байгууллагад буцаан хүргүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

3.2 ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОХИРУУЛГА, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

- 3.2.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын шаардлага хангаагүй тоног төхөөрөмжид тохируулга, засвар үйлчилгээг эмнэлгүүдийн инженер техникчтэй хамтран гүйцэтгэнэ.
- 3.2.2 Уг хэлтсийн инженер, техникийн ажилтнууд нь хавсралт 3-т заасан хяналт тохируулга, засвар үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.
- 3.2.3 Эрүүл мэндийн салбарт хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хэмжил зүйн техникийн судалгааг гаргаж бодлогын түвшинд шийдвэрлүүлэх, төсөл, хөтөлбөрт арга хэмжээнд санал боловсруулна.

3.3 ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.3.1 Эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протезийн ангилал нэршлийг олон улсын стандарт, жишигт тохируулан боловсронгуй болгох.
- 3.3.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн менежментийн арга аргачлалыг боловсруулж, олон улсын түвшинд хэрэглэгдэж буй UMDNS code буюу эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх.
- 3.3.3 Эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн программ хангамж дээр суурилсан системийг бий болгох.
- 3.3.4 Салбарын хэмжээнд ажиллаж байгаа инженер техникийн, болон санхүү бүртгэлийн ажилтнуудад эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн менежментийн сургалтыг тогтмол явуулах.
- 3.3.5 Бүртгэлийн систем дээр суурилан тоног төхөөрөмжийн ашиглалт, хэвийн ажиллагаа, засвар үйлчилгээ, аюул, эрсдлийн талаархи мэдээллийн санг бүрдүүлж, ЭМЯ-д хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого төлөвлөлт хийхэд, хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хянахад, салбарын хэмжээний хөрөнгө оруулалтын хэрэгцээг тогтоох гэх мэт үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор жил бүр тогтсон маягийн дагуу тайлан гаргаж, ЭМЯ-нд өгөх.
- 3.3.6 Таван жил тутамд эрүүл мэндийн салбарт хэрэглэгдэж байгаа төрийн өмчит эмнэлгүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл, тооллогыг хийх, цуглуулсан мэдээллийг эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн мэдээний санд оруулж, шинэчлэх ажлыг зохион байгуулах.
- 3.3.7 Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүдээс өөр бусад санхүүжилтийн эх үүсвэрээр (төсөл хөтөлбөр, хандив тусламж, эмнэлгийн өөрийн санхүүжилтээр, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гэх мэт) худалдан авч байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа мэдээллийг жил болгон авч нэгтгэн мэдээллийн санд төвлөрүүлэх ажлыг хийж гүйцэтгэх.

3.3.8 Эрүүл мэндийн салбарын хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй нягт хамтын ажиллагаатай ажиллаж, өндөр технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг авч мэдээний сан бүрдүүлэх

87

3.4 ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ИНЖЕНЕР, ТЕХНИКЧ, ЭМЧ
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

3.4.1 Салбарын хэмжээнд ажиллаж байгаа инженер техникийн ажилтнуудад эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагаа, чанарын менежментийн чиглэлээр тогтмол сургалт явуулах

3.4.2 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд болон бусад шатлалын эмнэлгүүдэд тоног төхөөрөмжийн чанарын менежментийн системийг бий болгох зорилгоор холбогдох мэргэжилтнүүдэд сургалт явуулах, ажлын зааварчилгаа, гарын авлагаар хангах.


Дөрөв. Албаны хамтын ажиллагаа

4.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн алба нь дараах байгууллагуудтай хамтран ажиллана.

- Эрүүл мэндийн яам
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв,
- Эрүүл мэндийн салбарын улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч, эмч мэргэжилтэн бэлтгэдэг улсын болон хувийн хэвшлийн их дээд сургуулиуд
- Техникийн засвар, үйлчилгээний болон ханган нийлүүлэгч компаниуд
- Гадаад орон, олон улсын болон төрийн бус байгууллагууд

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ,
СУРГАЛТ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ
БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОН ТОО, ЧИГ ҮҮРЭГ

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн төвийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нэг хэлтсийн бүтэц зохион байгуулалтаар ажиллана. Нийт 10 хүний орон тоогоор ажиллана.



1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн албаны дарга - (1)

- 1.1 ЭМЯ-ны бодлогын хүрээнд хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулан явуулах,
- 1.2 Эрүүл мэндийн салбарт хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх,
- 1.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналтын асуудлаар нийслэл, аймаг, орон нутгийн хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангах, сургалт, мэдээлэл, арга зүйн туслалцаа үзүүлэх,
- 1.4 Чанарын хяналт, тохируулга, стандарт, аюулгүй ажиллагааны чиглэлийн ажлыг зохион байгуулан явуулах,
- 1.5 Салбарын хэмжээний хэмжил зүйн дүрэм, журам батлуулж мөрдүүлэх,

2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт хариуцсан мэргэжилтэн - (4)

- 2.1 Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналтыг хийж, баталгаажуулан гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулан явуулах,
- 2.2 Эмнэлгийн техникийн өдөр тутмын үзлэг, шалгалт тохируулгыг хийх журам боловсруулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах,
- 2.3 Эмнэлгийн техникийн аюулгүй ажиллагааны журмыг олон улсын жишгийн дагуу боловсруулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах,

3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тохируулга, засвар үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн - (2)

3.1 Чанарын хяналтаар шаардлага хангаагүй тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийгдсэний дараа шалгалт тохируулгад хамруулж шалгалт тохируулгын гэрчилгээг олгох,

3.2 Төлөвлөгөөт болон урсгал засвар үйлчилгээ хийлгүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын судалгаа авах,

3.3 Чанарын хяналтаар шаардлага хангаагүй тоног төхөөрөмжийг актлах, үйл ажиллагаанаас хасах дүгнэлт гаргах

4. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл мэдээлэл, судалгаа хариуцсан мэргэжилтэн - (2)

4.1 Эрүүл мэндийн салбарын хөрөнгийн төлөвлөлтөнд шаардагдах суурь судалгааны ажлыг зохион байгуулах,

4.2 Хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, сонгон шалгаруулах, батлагаажуулах ажлыг зохион байгуулж, зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх

4.3 Хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, сонгон шалгаруулах, батлагаажуулах зохицуулах зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах

4.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил, ангилалын кодчлолыг боловсруулж, нэгдсэн бүртгэл мэдээний санг үүсгэх

4.5 Нэгдсэн мэдээний сангийн баяжуулалт хийх

4.6 Эрүүл мэндийн салбарын барилга байгууламж, дэд бүтцийн асуудал, эмнэлгийн барилгын стандарт, аюулгүй ажиллагааны чиглэлийн ажлыг зохион байгуулан явуулах,

4.7 Эмнэлгийн барилга, дэд бүтцийн асуудлаар нийслэл, аймаг, орон нутгийн хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангах, сургалт, мэдээлэл, арга зүйн туслалцаа үзүүлэх

5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникч, эмч, мэргэжилтний сургалт хариуцсан мэргэжилтэн - (1)

5.1 Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй инженер, техникийн ажилтнуудад мэргэжлийн сургалт, семинар, зөвлөлгөөнийг ЭМЯ, ШУТИС, ЭМШУИС болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран зохион байгуулан явуулах,

5.2 Эмнэлгийн техникийн засвар үйлчилгээ болон ашиглалтын талаар гарын авлага боловсруулах,

5.3 Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй инженер, техникийн ажилтнуудын бүртгэлийн сантай болж, мэргэшүүлэх, чадавхижуулах, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЯНАЛТ ТОХИРГОО,
 ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ
 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үйл ажиллагааны зориулалт	Тоо ширхэг
1	Дефибриллятор шалгагч төхөөрөмж Defibrillator, pacemaker analyzer	Бүх төрлийн дефибриллятор болон пасемакерийг шалгаж, дефибрилляторын гар болон автомат ажиллагааг шалгах, гаралтын хүчийг хэмжиж дүн шинжилгээг хийнэ.	2
2	Коагуляцын аппарат шалгагч төхөөрөмж Electrosurgery Analyzer	Бүх төрлийн коагуляцын аппаратыг шалгаж, мэс заслын цахилгаан түлэгч аппаратын ажиллагааг шалгаж дүн шинжилгээ хийнэ.	2
3	Инкубатор шалгагч төхөөрөмж Incubator analyzer	Нярайн инкубаторын дотоод орчны чийгшил, температур, агаарын урсгал, дууны түвшинг удаан хугацаагаар хэмжилт хийн дүн шинжилгээ хийнэ.	2
4	Хяналтын монитормын шалгагч төхөөрөмж Patient monitor simulator	Бүх төрлийн өвчтний монитормын ECG, TEMP, NIBP, SpO2, IBP, RESP –ийг шалгах дүн шинжилгээ хийнэ.	2
5	Хийн урсгал хэмжигч төхөөрөмж Gas flow analyzer	Хийн эзэлхүүн, даралт, урсгал болон оролт гаралтын хугацаа, хоорондын харьцааг тодорхойлж дүн шинжилгээ хийнэ.	2
6	Цахилгааны аюулгүй байдал чанар шалгагч төхөөрөмж Electrical safety analyzer	Тоног төхөөрөмжийн цахилгааны аюулгүй ажиллагааг шалгаж, симулятор болон мультметр болгон ашиглагдана.	2
7	Хүчилтөрөгчийн агууламж тодорхойлогч төхөөрөмж Oxygen analyzer	Хүчилтөрөгчийн агууламжийг тодорхойлно.	2
8	Шингэний шахуургын анализатор Infusion Device Analyzers	2 сувгаар шингэний урсгалын хурд, даралт, эзэлхүүнийг хэмжих дүн шинжилгээ хийнэ.	2
9	Зөөврийн осцилоскоп Scopemeter portable oscilloscope	Хувьсах болон тогтмол хүчдлийн давтамжийг хэмжиж график дүрслэлээр харуулж дүн шинжилгээ хийнэ.	2
10	Рентген болон компьютер томографийн аппарат шалгах төхөөрөмж X-Ray and CT test tools	Рентген цацрагаар оношлогоо хийдэг тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хянаж дүн шинжилгээ хийнэ.	2
11	ЭХО аппарат шалгах фантом Ultrasound Phantom	Хэт авиагаар оношлогоо хийдэг тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хянана.	2
12	Дижитал чадал хэмжигч Digital Powermeter	Хэмжилт тохиргоо хийх тоног төхөөрөмжийн оролтын чадал хүчдэл гүйдлийг хэмжинэ.	3
13	Нүдний даралт хэмжигч жишиг /эталон/ тонометр	Нүдний хараа, даралт, ...-ийн тонометрийн хэмжих үзүүлэлтийг харьцуулан хэмжиж шалгаж тохируулах	1
14	Хурд, хурдатгал хэмжигч ажлын эталон багаж	Центрфугний эргэлтийн хурдыг хэмжиж шалгаж тохируулах	1

15	Эргэлтийн хүч, эргэлтийн хурд, давтамжийг хэмжих калибратор	"Ergometer"-физик эмчилгээнд ашигладаг хүний биеийн хүчийг /гүйлт, хүчний үеийн/ хэмжих төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг шалгаж тохируулах	1
16	Нам давтамж, дуу чимээ хэмжигч эталон хэрэгсэл	Сонсголын аудиометрийг болон дуу авианы нам давтамжийг хэмжиж шалгаж тохируулах	1
17	Кламппметер Clampmeter	Powermeter-ээр хэмжих боломжгүй өндөр чадалтай тоног төхөөрөмжийн гүйдэл хэмжихэд хэрэглэнэ.	2
18	Хувьсах гүйдлийн дижитал стеблизатор AC stabilized power supply	Хэмжих тоног төхөөрөмжийн оролтын зөвшөөрөгдсөн хүчдэл болон давтамжийг хэмжилт хийх хугацаанд тогтвортой гаргаж тогтворжуулна.	2
19	Тогтмол гүйдлийн дижитал стеблизатор DC stabilized power supply	Хэмжих тоног төхөөрөмжийн оролтын зөвшөөрөгдсөн хүчдлийг хэмжилт хийх хугацаанд тогтвортой гаргаж тогтворжуулна.	2
20	Проб Probe 1:1000	Тоног төхөөрөмжийн залгуурыг салгах үед хэмжих Discharge шалгалтын үед болон өндөр потенциал өндөр давтамж бүхий физик эмчилгээний аппаратны гаралтыг хэмжихэд хэрэглэгдэнэ.	1
21	Oscilloscope	Бүх төрлийн цахилгаан сигналийг хэмжиж графикаар дүрслэн харах	2
22	Withstanding Voltage Tester	Тоног төхөөрөмжийн цахилгаан тусгаарлах чадварыг шалгахад хэрэглэнэ	1
23	Tester	Хяналт тохиргоо хийж байгаа тэрэгжилтнүүдийн хэрэглэх үндсэн хэмжих хэрэгсэл	5
24	Temperature recorder	IEC60601-1 стандартад хэрэглэх үндсэн төхөөрөмж бөгөөд тоног төхөөрөмжийн бүх элемент болон гадаргуун температурыг хэмжихэд хэрэглэнэ	3
25	Leakage current measuring instrument	IEC60601-1 стандартын дагуу тоног төхөөрөмжийн алдагдал гүйдлийг хэмжинэ	1
26	Иж бүрэн компьютер, ширээ сандалын хамт	Бүртгэл мэдээлэл, сургалт судалгаанд хэрэглэгдэнэ.	5
27	Олон үйлдэлтэй принтер	Бүртгэл мэдээлэл, сургалт судалгаанд хэрэглэгдэнэ.	5
28	Электроник засварын иж бүрдэл багаж	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, хяналт тохиргооны үйл ажиллагаанд хэрэглэгдэнэ.	5
29	Dielectric Resistance	Тоног төхөөрөмжид өвчтөний оронд залгах цахилгаан үл дамжуулах эсэргүүцэл	20
30	Дулааныг цахилгаан потенциалд хувиргах утас	Тоног төхөөрөмжийн температур хэмжихэд хэрэглэнэ.	300
31	Тугалга	Тоног төхөөрөмжид шаардлагатай үед гагнуур хийхэд хэрэглэнэ.	2
32	Гагнуурын алх	Тоног төхөөрөмжид шаардлагатай үед гагнуур хийхэд хэрэглэнэ.	2
33	Жижиг оврын цэгэн гагнуур	Дулааныг цахилгаан потенциалд хувиргах утас гагнахад хэрэглэгдэнэ.	1
34	Тугалга сорогч	Гагнуур хийх үед хэрэглэнэ	2
35	Температур чийгшил хэмжигч	Хэмжилгийн өрөөний чийгшил болон температурыг хэмжиж тэмдэглэгээ	2

		хийхэд хэрэглэнэ.	
36	Цахилгаан утас	Хэмжилгийн өрөөнд цахилгаан монтаж шинээр хийнэ.	300
37	Ерөнхий шит /цахилгааны самбар/	Хотын ерөнхий цахилгаанаас ирэх үндсэн шугаман дээр тавих хамгаалалтын шит /цахилгааны самбар/	1
38	Автомат пускатель	Шалгалт хийх залгуур бүр дээр байрлана.	10
39	Цахилгаан залгуур	Шалгалтын ширээнд суурилагдана	10
40	Шалгалт тохиргоо явуулах зориулалтын ширээ	Шалгалт явуулахад хэрэглэгдэнэ.	4

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАЙЛШГҮЙ ЧАНАРЫН ХЯНАЛТ
ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

1. Хийн урсгал хэмжигч төхөөрөмжөөр (Gas flow analyzer) зайлшгүй хяналт тохиргоо хийгдэх төхөөрөмжүүдийн нэрс:
 - 1.1. Амьсгалын аппарат (ventilator)-Үүнд дараах бүх төрлийн амьсгалын аппаратууд хамрагдана.
 - 1.1.1. Хүүхэд нярайн амьсгалын аппарат (Ventilators, Intensive Care, Neonatal/Pediatric)
 - 1.1.2. Амьсгалын аппарат, эрчимт эмчилгээний зориулалттай (Ventilators, Intensive Care)
 - 1.1.3. Яаралтай тусламжийн амьсгалын аппарат (Ventilators, Transport)
 - 1.1.4. Зөөврийн амьсгалын аппарат (Ventilators, Portable)
 - 1.2. Унтуулгын аппарат (Anesthesia Unit)
 - 1.3. Хүчилтөрөгч өтгөрүүлэгч (Oxygen Concentrators)
 - 1.4. Сорох төхөөрөмж (Aspirators)-Үүнд дараах бүх төрлийн аппаратууд хамрагдана.
 - 1.4.1. Сорох төхөөрөмж, шүдний (Aspirators, Dental)
 - 1.4.2. Сорох төхөөрөмж, бага чадлын (Aspirators, Low Volume)
 - 1.4.3. Сорох төхөөрөмж, мэс заслын (Aspirators, Surgical)
 - 1.4.4. Сорох төхөөрөмж, яаралтай тусламжийн (Aspirators, Emergency)
 - 1.4.5. Сорох төхөөрөмж, дурангийн (Aspirators, Endoscopic Irrigation)
 - 1.4.6. Сорох төхөөрөмж, умайн хүзүүний (Aspirators, Endoscopic Irrigation)
2. Хүчилтөрөгчийн агууламж тодорхойлогч төхөөрөмжөөр (Oxygen analyzer) зайлшгүй хяналт тохиргоо хийгдэх төхөөрөмжүүдийн нэрс:
 - 2.1. Хүчилтөрөгч өтгөрүүлэгч (Oxygen Concentrators)
 - 2.2. Хүчилтөрөгчийн генератор (Oxygen Generators)
 - 2.3. Амьсгалын аппарат (ventilator)
3. Шингэний шахуургын анализатороор (Infusion Device Analyzers) зайлшгүй хяналт тохиргоо хийгдэх төхөөрөмжүүдийн нэрс:
 - 3.1. Тариурын шахуурга (Syringe Pumps)-Үүнд дараах бүх төрлийн аппаратууд хамрагдана.
 - 3.1.1. Тариурын шахуурга, олон сувагтай (Syringe Pumps, Multichannel)
 - 3.1.2. Тариурын шахуурга, нэг сувагтай (Syringe Pumps, Singlechannel)
 - 3.1.3. Тариурын шахуурга, инсулин антибиотик гэх мэт тусгай зориулалтын (Syringe Pumps, Specialized purpose (e.g., insulin, antibiotics only))
 - 3.2. Дуслын шахуурга (Infusion Pumps)
4. Цахилгааны аюулгүй байдал чанар шалгагч төхөөрөмжөөр (Electrical safety analyzer) зайлшгүй хяналт тохиргоо хийгдэх төхөөрөмжүүдийн нэрс:
 - 4.1. Унтуулгын аппарат (Anesthesia Unit)
 - 4.2. Амьсгалын аппарат (ventilator)-Үүнд дараах бүх төрлийн амьсгалын аппаратууд хамрагдана.
 - 4.2.1. Хүүхэд нярайн амьсгалын аппарат (Ventilators, Intensive Care, Neonatal/Pediatric)
 - 4.2.2. Амьсгалын аппарат, эрчимт эмчилгээний зориулалттай (Ventilators, Intensive Care)
 - 4.2.3. Яаралтай тусламжийн амьсгалын аппарат (Ventilators, Transport)
 - 4.2.4. Зөөврийн амьсгалын аппарат (Ventilators, Portable)
 - 4.3. Дефибрилятор (Defibrillator)- Үүнд дараах бүх төрлийн амьсгалын аппаратууд хамрагдана.

- 4.3.1. Хагас автомат Дефибрилятор (Defibrillators, External, Semi-Automated)
 - 4.3.2. Бүтэн автомат Дефибрилятор (Defibrillators, External, Automated)
 - 4.4. Коагуляцын аппарат (Electrosurgical Units)-Үүнд дараах бүх төрлийн амьсгалын аппаратууд хамрагдана.
 - 4.4.1. Коагуляцын аппарат, монополяр (Electrosurgical Units, Monopolar)
 - 4.4.2. Коагуляцын аппарат, биполяр (Electrosurgical Units, Bipolar)
 - 4.4.3. Коагуляцын аппарат, монополяр /биполяр (Electrosurgical Units, Monopolar/Bipolar)
 - 4.5. Өвчтөний хяналтын монитор (Physiologic monitoring system, single-patient)
 - 4.5.1. Өвчтөний хяналтын монитор (Physiologic monitoring system, single-patient)
 - 4.5.2. Зөөврийн өвчтөний хяналтын монитор (Transportable physiologic monitoring system)
 - 4.5.3. Нярайн хяналтын монитор (Neonatal physiologic monitoring system)
 - 4.6. Сорох төхөөрөмж (Aspirators)-Үүнд дараах бүх төрлийн аппаратууд хамрагдана.
 - 4.6.1. Сорох төхөөрөмж, шүдний (Aspirators, Dental)
 - 4.6.2. Сорох төхөөрөмж, бага чадлын (Aspirators, Low Volume)
 - 4.6.3. Сорох төхөөрөмж, мэс заслын (Aspirators, Surgical)
 - 4.6.4. Сорох төхөөрөмж, яаралтай тусламжийн (Aspirators, Emergency)
 - 4.6.5. Сорох төхөөрөмж, дурангийн (Aspirators, Endoscopic Irrigation)
 - 4.6.6. Сорох төхөөрөмж, умайн хүзүүний (Aspirators, Endoscopic Irrigation)
 - 4.7. Хүчилтөрөгч өтгөрүүлэгч (Oxygen Concentrators)
 - 4.8. Тариурын шахуурга (Syringe Pumps)-Үүнд дараах бүх төрлийн аппаратууд хамрагдана.
 - 4.8.1. Тариурын шахуурга, олон сувагтай (Syringe Pumps, Multichannel)
 - 4.8.2. Тариурын шахуурга, нэг сувагтай (Syringe Pumps, Single channel)
 - 4.8.3. Тариурын шахуурга, инсулин антибиотик гэх мэт тусгай зориулалтын (Syringe Pumps, Specialized purpose (e.g., insulin, antibiotics only))
 - 4.9. Дуслын шахуурга (Infusion Pumps)
 - 4.10. Пульсоксиметр, суурин (Oximeters, Pulse)
 - 4.11. Физик эмчилгээний цахилгаан эмчилгээний тоног төхөөрөмж (Electrotherapy equipment and Physiotherapy equipment)
 - 4.11.1. Лазер эмчилгээний аппарат (Laser therapy equipment)
 - 4.11.2. Хэт авиа эмчилгээний аппарат (Ultrasound therapy equipment)
 - 4.11.3. Muscle stimulator unit
 - 4.11.4. Нам давтамжийн эмчилгээний аппарат (Shortwave Diathermy unit)
 - 4.11.5. Хэт богино долгионы эмчилгээний аппарат (Diathermy Units, Microwave)
 - 4.11.6. Парафин эмчилгээний банн (Baths, Paraffin, Physical Therapy)
 - 4.11.7. Фото эмчилгээний аппарат (Phototherapy Units)
 - 4.11.8. Массажны аппарат (Massage Machines, Physical Therapy)
 - 4.12. Бүх төрлийн уурын автоклав (Sterilizing Units, Steam)
 - 4.12.1. Суурин уурын автоклав (Sterilizing Units, Steam, Bulk)
 - 4.12.2. Ширээний уурын автоклав (Sterilizing Units, Steam, Tabletop)
5. Нүдний хараа, даралт...-ийн "тонометр"-ийн хэмжих үзүүлэлтийг харьцуулан хэмжиж шалгаж тохируулах
6. Центрифугний эргэлтийн хурдыг хэмжиж шалгаж тохируулах
7. "Ergometer" - физик эмчилгээнд ашигладаг хүний биеийн хүчийг /гүйлт, хүчний үеийн/ хэмжих төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг шалгаж тохируулах
8. Сонсголын аудиометрийг болон дуу авианы нам давтамжийг хэмжиж шалгаж тохируулах

ЭМЯ-ны харьяа байгууллага, лавлагаа төвүүдээс
шилжүүлэн авах мэргэжилтэнүүдийн тоо

№	Эмнэлгийн нэр	Мэргэжилтэний тоо
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	1
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	1
3	Улсын гуравдугаар төв эмнэлэг	1
4	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	1
5	Гэмтэл согог судлалын үндэсний төв	1
6	Хавдар судлалын үндэсний төв	1
7	Халдварт өвчин судлалын үндэсний төв	1
8	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1
9	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	1
10	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	1
	БҮГД	10